



ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХҮҮН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 04

Зуунмод

Г Аймгийн Засаг даргын 2020-2024 оны
үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн
явцын тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 52 зорилт, 274 арга хэмжээний хэрэгжилтийн явц 95.29 хувийн гүйцэтгэлтэй тул "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсүгэй.

2. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнг бататгаж, "эрчимжүүлэх шаардлагатай" ажлуудад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэн, бүрэн эрхийн хугацаанд багтаан хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хороодод үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЖАМБАЛСҮРЭН